



**“ТҮМЭН ШУВУУТ” ХК-ИЙН ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ**

Хагас жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 2/	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа /Жишээ нь:	2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдөр/
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	“Түмэн шувуут” ХК, 000188646, MSE:TUM, 70005225
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	-
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	200,000,000
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Д.Наранцэцэг Хянасан: Гүйцэтгэх захирал Ж.Болд
1.1.	Хагас жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт
	Аудит бүтэн жилээр хийгдэхээр 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан тул жилийн тайланд аудитын дүгнэлтийг хавсаргана.
1.2.	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/
	Аудит бүтэн жилээр хийгдэхээр 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан тул жилийн тайланд аудитын тодорхойлох захидлыг хавсаргана.
2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/
	Санхүүгийн үзүүлэлтүүд
	Ашигт ажиллагаа
	Нийт хөрөнгийн өгөөж (ROA) 15%
	Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) 25%
	Өөрчлөлтийн хувь /оны эхнээс/
	Нийт активын өөрчлөлт 35%
	Зээлийн багцын өөрчлөлт 70%
	Хөрөнгөнд эзлэх хувь
	Өөрийн хөрөнгө /Нийт хөрөнгө 62%
	Өр төлбөр/Нийт хөрөнгө 38%
	Хөрвөх чадварын харьцаа
	Хөрвөх чадварын хөрөнгө /Татан төвлөрүүлсэн хөрөнгө
2.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос
	• ОХУ-аас худалдан авдаг тэжээлийн түүхий эдийн олдоц муудаж, тэжээл тасалдах хүндрэлээс

	<p>үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</p>	<p>урьдчилан сэргийлэн БНХАУ-аас зарим түүхий эдийг худалдан авахаас гадна дотоодоос худалдан авч нөөц бүрдүүлж байна.</p> <p>• Үйл ажиллагаагаа тэлж, үйлдвэрлэл нэмэгдэж байгаатай холбогдуулан өндөгний цаасан үүрийг мөн гаднаас импортлон авч байна.</p>
2.4	<p>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/</p>	<p>Санхүү байдлын тайлангаас гадуурх бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.</p>
2.5	<p>Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;</p>	<p>Тайлант хугацаанд:</p> <ul style="list-style-type: none"> • “Тэжээлийн түүхий эд худалдан авах зорилгоор ХХААХҮЯ-ны тахианы аж ахуй эрхлэгчдэд олгох хөнгөлөлттэй зээлийн нөхцөлөөр Хаан банкнаас 36 сарын хугацаатай, жилийн 5 %-ийн хүүтэй, 1.000.000.000 /Нэг тэрбум/ төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээл авсан. Зээлийн барьцаанд 4 үл хөдлөх хөрөнгө тоног төхөөрөмжийн хамт, 1 газар /ТУЗ-ийн 2024 оны 02 сарын 19-ний өдрийн хурлаар шийдвэрлэв/ барьцаалсан. • Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэн “Түмэн шувуут-3” төслийг хэрэгжүүлэх зорилгоор ХХААХҮЯ-ны хөнгөлөлттэй зээлийн нөхцөлөөр Голомт банкнаас 60 сарын хугацаатай, жилийн 6%-ийн хүүтэй, 15,000,000.000 /Арван таван тэрбум/ төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл авсан. Зээлийн барьцаанд 8 үл хөдлөх хөрөнгө тоног төхөөрөмжийн хамт, 5 газар / ТУЗ-ийн 2024 оны 02 сарын 19-ний өдрийн хурлаар шийдвэрлэв./ барьцаалсан. <p><i>/Зээлийн мэдээллийг 2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар хавсаргав. /</i></p>
3.	<p>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</p>	
	<p>Байхгүй</p>	
4.	<p>Цалин урамшууллын мэдээлэл</p>	
	<p>2024 онд ТУЗ-ийн Хараат болон хараат бус гишүүдэд 64,5 сая төгрөг, Гүйцэтгэх удирдлагад 132,9 сая төгрөгийн цалин олгосон байна.</p>	
5.	<p>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</p>	
	<ul style="list-style-type: none"> • ТУЗ нь 2024 оны эхний хагас жилийн хугацаанд нийт 5 удаа хуралдаж, үүнээс цахимаар 1 удаа, Биечлэн оролцсон 3 удаа, эчнээ хэлбэрээр 1 удаа хуралдаж, нийт 24 асуудалд үнэлэлт, дүгнэлт өгч, 11 шийдвэр гаргаж ажиллалаа. Мөн Нэр дэвшүүлэх хороо 2 удаа, Цалин урамшууллын хороо 1 удаа, Аудитын хороо 3 удаа, Ёс зүйн хороо 1 удаа тус тус хуралдаж холбогдох үүргийнхээ хувьд дүгнэлт гаргаж ажилласан байна. • ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан 2024 оны 04 сарын 27-ны өдөр зохион байгуулсан “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-аар шинэ ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг хэлэлцүүлэн баталсан. Үүнд: Ердийн гишүүд: Л.Эрхэмбаяр, Б.Тунгалаг, Ж.Болд, Э.Баяржаргал, А.Бакей, М.Болод Хараат бус гишүүд: Ц.Наран-Учрал, Г.Мөнх-Эрдэнэ, Ө.Оргил-Эрдэнэ нар сонгогдсон. 	

	<ul style="list-style-type: none"> • ТУЗ-ийн хурлын шийдвэрээр ТУЗ-ийн даргаар Л.Эрхэмбаярыг сонгож, ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Д.Наранцэцэгийг томилов. • ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны даргаар Ц.Наран-Учрал, гишүүдээр Ө.Оргил-Эрдэнэ, Э.Баяржаргал нарыг, Нэр дэвшүүлэх хорооны даргаар Г.Мөнх-Эрдэнэ, гишүүдээр М.Болод, Ц.Наран-Учрал нарыг, Цалин урамшууллын хорооны даргаар Ц.Наран-Учрал, гишүүдээр М.Болод, Г.Мөнх-Эрдэнэ нарыг, Ёс зүйн хорооны даргаар Ө.Оргил-Эрдэнэ, гишүүдээр Б.Тунгалаг, Г.Мөнх-Эрдэнэ нарыг тус тус баталлаа. • ТУЗ-ийн гишүүд компанийн үйлдвэрлэлийн шинэчлэлт, бүтээн байгуулалтын үйл явцтай биечлэн танилцаж, заавар зөвлөгөө өгч ажилласан. <div style="display: flex; justify-content: space-around;">   </div> <ul style="list-style-type: none"> • ТУЗ нь компанийн засаглалын кодексийн зарчмыг хэрэгжүүлэх үүднээс өөрийн үнэлгээг хийж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн ба засаглалын кодексийн өөрийн үнэлгээг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Д.Наранцэцэг, Хүний нөөцийн менежер Б.Нямбаяр нар гаргаж, нийт 67 оноо буюу 93%-ийн үнэлгээтэйгээр холбогдох байгууллага, хүмүүст танилцуулж ажиллалаа. КЗК-ийн хүрээнд тайлант жилд нэмэлтээр хийж гүйцэтгэх ажлуудыг 2025 оны ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэх ажлын төлөвлөгөөнд оруулан хийж гүйцэтгэх болно.
6.	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл
	Байхгүй
7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/
	Нийт хувьцаа эзэмшигчийн тоо 2024 оны 04-р сарын 09-ны өдрийн байдлаар 15409 үүнээс 5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигч 4 хүн буюу Л.Эрхэмбаяр 60,000,000 ширхэг хувьцаа-30%, Б.Тунгалаг 60,033,855 ширхэг хувьцаа ба 30,02%, Ж.Болд 20,000,000 ширхэг хувьцаа ба 10%, Э.Баяржаргал-20,000,000 ширхэг хувьцаа ба 10% тус тус эзэмшиж байна.
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл
	2024 оны эхний хагаст татан төвлөрүүлсэн хөрөнгө байхгүй
9.	Ногдол ашгийн мэдээлэл
	2023 оны цэвэр ашгийн 30%-ийг Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилах шийдвэрийг 2024 оны 02-р сарын 19-ны өдрийн ТУЗ-ийн хурлаас нэгж хувьцаанд 17,1 төгрөг гарах шийдвэр гаргаж, тус оны 04-р сарын 30-ны өдрийн дотор “ҮЦТХТ” ХХКомпаниар дамжуулан тараасан. Мөн Голомт капитал ҮЦКомпани “Голомт кастодиан”-нд бүртгэлтэй хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг тус байгууллагын дансанд шилжүүлсэн.
10.	Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл
	<p style="text-align: center;">ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ХҮРЭЭНД:</p> <p>1. “Түмэн шувуут” ХК-ийн нийт ажилчдынхаа хүүхдүүдэд зориулан үйлдвэр тус бүр дээр хүүхдийн баярын арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Хүүхэд бүр аав ээжийнхээ ажилтай танилцахын зэрэгцээ үлгэрийн баатруудтай хамтдаа нэгэн өдрийг хөгжилтэй, дурсамж дүүрэн өнгөрөөлөө.</p>



2. “Түмэн шувуут” ХК-ийн инженер техникийн ажилчид бидэнтэй хамтран ажилладаг БНХАУ-ын FAMSUN компанид зочлон ажлын туршлага судлан техник тоног төхөөрөмжийн үйл ажиллагаатай нь танилцаад ирлээ.
3. Ажилчдынхаа сурч боловсрох, мэдлэг ур чадвараа дээшлүүлэхэд байгууллагын зүгээс



анхаарч ажилладаг тул нийт тогооч нарт зориулан ажлын байранд нь мэргэжлийн зэрэг ахиулах сургалтыг зохион байгууллаа.



4. Уламжлал болгон зохион байгуулдаг “Шинэ ажилтны аялал” амжилттай боллоо. Аялалаар “Түмэн шувуут” ХК-д шинээр ажилд орсон ажилтнууд маань Шувууны аж ахуй-1, Шувууны аж ахуй-2, Агро фийд тэжээлийн үйлдвэр болон төв оффистой танилцан өөрсдийн сонирхсон асуултанд хариулт авсан юм.



5. “Түмэн шувуут” ХК-ийн нийт ажилчдад зориулан жил бүр зохион байгуулдаг спортын арга хэмжээг 4 төрлөөр амжилттай зохион байгуулж шилдэгүүдээ тодрууллаа.



6. “Түмэн шувуут” ХК-ийн “Чанарын хяналтын лаборатор”-ийн химич, микробиологич ажилтнууд тус компанитай олон жил хамтарч ажилласаар ирсэн БНХАУ-

ын Wellhope компанийн үйл ажиллагаатай танилцаж, ур чадвараа ахиулах, практик сургалтанд хамрагдаад ирлээ.



7. **Micro World LLC** -тай хамтран "Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага" ISO/IEC 17025:2017 (MNS ISO/IEC 17025:2018) стандартын шаардлагын дагуу сургалтанд лабораторийн нийт ажилтнуудаа хамрууллаа.



8. Малын эмч, технологийн ажилтнуудаа чадавхжуулах ажлын хүрээнд Малайз улсаас мэргэшсэн малын эмч Daniel Mohan-ийг урьж, танхимын болон онлайн-аар, онол практик хослуулсан 2 шатлалт сургалтыг амжилттай зохион байгууллаа.



9. “Түмэн шувуут” ХКомпанийн үүсэн байгуулагдсаны 20 жилийн ой 2024 онд тохиосон бөгөөд байгууллагын урт хугацаанд оршин тогтнож, үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад ажилтан бүрийн хичээл зүтгэл чухал үүрэгтэй байдаг. Иймээс ойн хүрээнд үүсэн байгуулагдсан цагаас одоог хүртэл тасралтгүй үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллаж байгаа 100 орчим ажилчидаа Төрийн дээд одон медаль, мөнгөн шагнал, гадаадад

аялах эрхийн бичгээр шагнаж урамшуулсан нь ажилчдад цаашид ажиллах эрч хүчийг нэмэгдүүлсэн ач холбогдолтой үйл явдал болсон.



БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ХҮРЭЭНД:

1. “Түмэн шувуут” ХКомпани нь 2024 оны эхнээс “Түмэн шувуут-3” тахианы аж ахуйн шинэ фермийг барихаар төлөвлөн бүтээн байгуулалтын ажлаа эхлүүлээд байна. Тус аж ахуй нь 400,000 өндөглөгч шувууны 8 байр 100,000 дэгдээхэйн 2 байртай юм. “Түмэн шувуут-3” аж ахуйг шинээр байгуулснаар “Түмэн шувуут” ХКомпанийн өндөглөгч шувууны тоо толгой 1 сая, дэгдээхэйн тоо толгой 300,000-д хүрч, жилд 230-250 сая ширхэг өндөг үйлдвэрлэж, дотоодын өндөгний хэрэглээний 50 хувийг дангаараа хангах боломжтой ба жилд 230-250 сая.ш өндөг үйлдвэрлэж бусад аж ахуйн үйлдвэрлэлийн хамт дотоодын хэрэглээний 90%-ийг хангах нөхцөл бүрдэнэ. Мөн хотын захын дүүрэгт шинээр ажлын байр бий болгож 120 хүнийг байнгын ажлаар хангах юм. 2024 оны 12 сарын 04-ний өдөр “Түмэн шувуут-3” аж ахуйн Дэгдээхэйн 1-р байр ашиглалтанд орж 50,000 дэгдээхэйгээ хүлээн авсан. Одоогийн байдлаар Дэгдээхэйн 2-р байр болон Өндөглөгчийн дөрвөн байр бүрэн баригдаж, тоног төхөөрөмжөө угсарч эхлээд үйлдвэрлэл явуулах бэлтгэлээ хангаад байна.



2. “Түмэн шувуут” ХК-ийн тэжээлийн үйлдвэр нь өөрийн хүчин чадлаа нэмэгдүүлэхийн тулд тоног төхөөрөмжийн өргөтгөл шинэчлэлтийн ажлыг хийж, нэмэлтээр түүхий эдийн 1 бункер, бэлэн бүтээгдэхүүний 4 бункер угсарч, цаашид савлагааны төхөөрөмжийг бүрэн автомат болгох бэлтгэл ажлаа хангасан.



3. “Түмэн шувуут-1” шувууны аж ахуйн дэргэд байрлах Инкубаторын цехийн хүчин чадлыг нэмэгдүүлэхийн тулд Үржлийн өндөг дарах байрыг өргөтгөн барьж өөрийн аж ахуйн болон бусад аж ахуйн сүргийн эргэлтийг хэрэгцээг хангах боломжийг 3 дахин нэмэгдүүлсэн.



НИЙГЭМД ЧИГЛЭСЭН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

1. Шинжлэх ухааны үндэслэлтэй орчин үеийн мал аж ахуйн салбарыг цогцоор нь хөгжүүлэх бодлогыг нэгтгэх зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Дэлхийн банкны мал аж ахуйн эргэлтийг нэмэгдүүлэх төслөөс дэмжин Хүнсний хувьсгал үндэсний хувьсгалын хүрээнд Монголын мал зүйч үржүүлэгчдийн үндэсний холбоо, Түмэн шувуут ХК-тай хамтран 2024 оны 6-р сарын 8-ны өдөр “Хонины аж ахуй эрхлэгчдийн зөвлөгөөн”-ийг зохион байгууллаа. Мал аж ахуйн салбарын эрдэмтэн, судлаачид, орон нутгийн мэргэжилтнүүд, хонины аж ахуй эрхлэгчид, малчдын төлөөлөл зэрэг нийт 260 гаруй хүн оролцож, хонины аж ахуйг эрчимжүүлэх, тэжээллэг арчилгаа, маллагааг сайжруулах чиглэлээр хэрэгжиж буй олон төсөл, хөтөлбөрийн туршилт, үр дүнтэй танилцаж, тулгамдаж буй асуудлын талаар харилцан санал солилцсон юм.



2. “Түмэн шувуут” ХКомпани нь анх 2004 онд үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаагаа эхлүүлсэний 20 жилийн ой тохиож буйтай холбогдуулан “Евро-Азийн өндөглөгч тахианы аж ахуйн өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага” форумыг амжилттай зохион байгуулсан. Уг арга хэмжээнд Монгол Улсын Засгийн газар, төрийн байгууллага, Хөрш 2 улсын харилцагч байгууллагууд болон Монголын тахианы аж ахуй эрхлэгчдийн төлөөлөл оролцсон арга хэмжээ болж өнгөрсөн.



БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ БАГАСГАХ БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

1. Иргэд, харилцагчдаас хаягдал цаасыг үнэлэн худалдан авч өндөгний цаасан үүр үйлдвэрлэсээр байна. Уг ажлын хүрээнд нийт 245 тн хаягдал цаасыг ашиглаж цаасан үүр үйлдвэрлэжээ.



2. Үйлдвэрээс гарах хаягдал буюу шувууны сангас жилд 3500 орчим тн хаягдаж, байгальд орчин, хөрс шороонд нөлөөлж байдаг. Үйлдвэрээс гарсан хаягдал сангасыг боловсруулан 2024 онд нийт 1000 тн 100% компост бордоо үйлдвэрлэв.



УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЭСРЭГ БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

1. ТШ-1 3260м² талбайд зулэгжүүлэлт хийж, автомат бороожуулагч суурилуулсан ба Гацуур 3 ширхэг, Хайлаас 210 ширхэг, Голт бор 5 ширхэг, Шар хуайс 5 ширхэг, Монгол сакура 9 ширхэг тус тус тариалсан бөгөөд нийт 231 ширхэг мод бут тариаллаа.



/Түмэн шувуут-3 аж ахуй (ХУД-ийн 13-р хороо, Туул тосгон)

2. ТШ-2 аж ахуйн хашаанд 2000ш улиас мод тарьсанаас 100ш улиас мод нөхөн сэргээж тарьсан.



Түмэн шувуут-2 аж ахуй (СХД-ийн 21-р хороо, Их булаг)

3. Тэжээлийн үйлдвэрийн хашааг дагуулан 420ш улиас тарьсан.



Тэжээлийн үйлдвэр (СХД-ийн 21-р хороо, Рашаант өртөө)

4. Агаарын бохирдол, тоосжилтийн хэмжээг бууруулахын тулд ХУД-ийн 13-р хороонд байрлах “Түмэн шувуут-1” шувууны аж ахуйн уурын зуух, СХД-ийн 21-р хороо, Рашаант өртөөнд байрлах Тэжээлийн үйлдвэрийн уурын зуухнуудыг тус тус шинэчилж суурилуулсан.



БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал, чанар стандартыг ханган ажиллахын тулд энэ оны 08 сараас Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001, Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO 22000 буюу Нэгдсэн менежментийн тогтолцоог хэрэгжүүлэхээр зөвлөх үйлчилгээ авч ажиллаж байна.





Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: ЖИГЖИД овогтой БОЛД
Албан тушаал: “Түмэн шувуут” ХК-ийн гүйцэтгэх захирал
Гарын үсэг:
(Тамга/тэмдэг)



Овог, нэр:
Албан тушаал:
Гарын үсэг:
(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: 2025-01-06

Овог, нэр: Д.Наранцэцэг
Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
Гарын үсэг: *Д. Наранцэцэг*